



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/170

Номгон

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын
түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлэх
тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 14 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын түргэвчилсэн оношлуурын нөөцийг бүрдүүлэх ажлыг яаралтай зохион байгуулсугай.

2. Эрүүл мэндийн яамнаас Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх оношлуурыг татан авч, аймгийн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т үүрэг болгосугай.

3. Түргэвчилсэн оношлуурт шаардагдах 15.000.000 /арван таван сая/ төгрөгийг Засаг даргын нөөцөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Д.Энхжаргал/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210435